АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2023/18-НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Архангай аймаг<br>2023 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Ахлах аудитор Н.Алтантуяа<br>Утас: 7033-3019<br>Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ........ 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан........ 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан........ 5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан........ 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан........ 7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 8
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**........ 9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........ 9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........ 9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ........ 10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........ 10
3.5.3 Нэмэлт төсөв ........ 11
**4. АУДИТЫН ТАЙЛАН**........ 12
4.1 Ерөнхий зүйл ........ 12
4.2 Материаллаг байдал........ 12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт........ 12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт........ 13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ........ 14
5.1 Албан шаардлага........ 14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ........ 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БГАҮТХ | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |
| ШШҮХ | Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн |
| ШША | Шүүхийн шинжилгээний алба |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.02.15 № 49

танай ____________-ны № ____________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА Б.ХОС-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10 дугаар тогтоол, "Шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц орон тоо шинэчлэн батлах тухай" Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/10 дугаар тушаалаар Шүүхийн шинжилгээний хэлтэс болсон байна.

**Аудитын гол асуудал**

Тайлангийн жилд тус байгууллагын дарга нь Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн Б/290 дүгээр тушаалаар томилогдсон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт, 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс 90.1 хувьтай үнэлсэн байна.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 2,051,695.00 | 7,126,275.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 2,051,695.00 | 7,126,275.00 |
| 35100 | Түүхий эд материал | 1,786,875.00 | 6,160,020.00 |
| 35130 | Эм боох материал | 1,786,875.00 | 6,160,020.00 |
| 35400 | Хангамжийн материал | 264,820.00 | 966,255.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 152,920.00 | 222,155.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 111,900.00 | 744,100.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 57,900,930.03 | 161,658,470.26 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 57,900,930.03 | 161,658,470.26 |
| 39200 | Биет хөрөнгө | 48,900,930.03 | 152,658,470.26 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 31,570,000.00 | 139,770,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -12,070,000.00 | -15,970,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 45,256,119.12 | 55,188,029.12 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -20,485,745.66 | -29,530,800.38 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 8,006,514.29 | 8,006,514.29 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -3,375,957.72 | -4,805,272.77 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 9,000,000.00 | 9,000,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,000,000.00 | 9,000,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 59,952,625.03 | 168,784,745.26 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 59,952,625.03 | 168,784,745.26 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 59,952,625.03 | 168,784,745.26 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 9,000,000.00 | 9,000,000.00 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 9,000,000.00 | 9,000,000.00 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 50,952,625.03 | 159,784,745.26 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 16,060,246.99 | 50,952,625.03 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 34,892,378.04 | 108,832,120.23 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 59,952,625.03 | 168,784,745.26 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 236,305,800.00 | 344,089,199.07 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 24,272,000.00 | 121,759,239.07 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 24,272,000.00 | 121,759,239.07 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 24,272,000.00 | 5,642,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,772,000.00 | 5,642,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 19,500,000.00 | 0.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 0.00 | 116,117,239.07 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 212,033,800.00 | 222,329,960.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 187,761,700.00 | 214,010,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 187,761,700.00 | 214,010,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 24,272,100.00 | 8,319,360.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 21,731,800.00 | 5,224,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,540,300.00 | 3,095,360.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 201,413,421.96 | 235,257,078.84 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 201,413,421.96 | 235,257,078.84 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 199,039,378.80 | 231,652,005.93 |

| | | | |
|---|---|---|---|
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 153,032,269.97 | 165,027,005.35 |
| 210101 | Үндсэн цалин | 83,422,986.25 | 101,247,305.35 |
| 210102 | Нэмэгдэл | 55,936,255.50 | 49,908,000.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,673,028.22 | 12,391,761.00 |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 1,479,939.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 3,568,915.64 | 3,744,210.44 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,148,915.25 | 691,449.34 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 60,536.12 | 45,589.75 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 44,228.90 | 36,471.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 12,307.23 | 9,117.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,302,928.14 | 2,961,581.60 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 12,636,689.23 | 12,607,083.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,431,509.00 | 1,603,425.00 |
| 210302 | Түлш, халаалт | 10,230,000.00 | 9,990,558.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 975,180.23 | 1,013,100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 12,532,815.00 | 16,705,648.30 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,813,310.00 | 1,400,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,070,300.00 | 12,541,660.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,409,205.00 | 1,608,588.30 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 590,000.00 | 626,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 650,000.00 | 528,500.00 |
| 2105 | Нормативт зардал | 4,700,000.00 | 7,889,475.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,700,000.00 | 7,830,475.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.00 | 59,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 450,000.00 | 791,480.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 459,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 450,000.00 | 331,980.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,633,300.00 | 3,294,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,633,300.00 | 3,294,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,053,967.00 | 7,903,005.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,591,600.00 | 5,994,265.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 297,832.00 | 234,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 138,375.00 | 331,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 269,700.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 1,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 4,160.00 | 73,540.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,431,421.96 | 13,689,698.84 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 6,431,421.96 | 13,689,698.84 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,374,043.16 | 3,605,072.91 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 2,374,043.16 | 3,605,072.91 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,374,043.16 | 3,605,072.91 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 34,892,378.04 | 108,832,120.23 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 34,892,378.04 | 108,832,120.23 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 216,805,800.00 | 227,971,960.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 4,772,000.00 | 5,642,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 4,772,000.00 | 5,642,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,772,000.00 | 5,642,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,772,000.00 | 5,642,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 212,033,800.00 | 222,329,960.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 187,761,700.00 | 214,010,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 187,761,700.00 | 214,010,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 24,272,100.00 | 8,319,360.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 21,731,800.00 | 5,224,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,540,300.00 | 3,095,360.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 194,982,000.00 | 226,641,960.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 194,982,000.00 | 226,641,960.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 192,607,956.84 | 223,036,887.09 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 153,032,269.97 | 165,027,005.35 |
| 210101 | Үндсэн цалин | 83,422,986.25 | 101,247,305.35 |
| 210102 | Нэмэгдэл | 55,936,255.50 | 49,908,000.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,673,028.22 | 12,391,761.00 |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 1,479,939.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 3,568,915.64 | 3,744,210.44 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,148,915.25 | 691,449.34 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 60,536.12 | 45,589.75 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 44,228.90 | 36,471.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 12,307.23 | 9,117.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,302,928.14 | 2,961,581.60 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 12,636,689.23 | 12,607,083.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,431,509.00 | 1,603,425.00 |
| 210302 | Түлш, халаалт | 10,230,000.00 | 9,990,558.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 975,180.23 | 1,013,100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 12,532,815.00 | 16,699,448.30 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,813,310.00 | 1,401,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,070,300.00 | 12,541,660.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,409,205.00 | 1,608,588.30 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 590,000.00 | 626,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 650,000.00 | 521,200.00 |
| 2105 | Нормативт зардал | 4,700,000.00 | 12,838,700.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,700,000.00 | 11,884,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.00 | 954,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 450,000.00 | 819,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 459,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 450,000.00 | 360,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,633,300.00 | 3,294,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,633,300.00 | 3,294,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,053,967.00 | 8,006,440.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,591,600.00 | 6,097,700.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 297,832.00 | 234,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 138,375.00 | 331,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 269,700.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 1,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 4,160.00 | 73,540.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,374,043.16 | 3,605,072.91 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 2,374,043.16 | 3,605,072.91 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,374,043.16 | 3,605,072.91 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 21,823,800.00 | 1,330,000.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 21,823,800.00 | 1,330,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 21,823,800.00 | 1,330,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 21,823,800.00 | 1,330,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 21,823,800.00 | 1,330,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -21,823,800.00 | -1,330,000.00 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | 0.00 | 0.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 0.00 | 0.00 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 9,000,000.00 | 0.00 | 16,060,246.99 | 25,060,246.99 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 9,000,000.00 | 0.00 | 16,060,246.99 | 25,060,246.99 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 34,892,378.04 | 34,892,378.04 |
| 10 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 9,000,000.00 | 0.00 | 50,952,625.03 | 59,952,625.03 |
| 11 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 9,000,000.00 | 0.00 | 50,952,625.03 | 59,952,625.03 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 9,000,000.00 | 0.00 | 50,952,625.03 | 59,952,625.03 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 108,832,120.23 | 108,832,120.23 |
| 20 | 2022 оны 12-р сарын 30-нээрх үлдэгдэл | 9,000,000.00 | 0.00 | 159,784,745.26 | 168,784,745.26 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 218,010,600.00 | 216,047,527.09 | 1,963,072.91 | 99.10 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 218,010,600.00 | 216,047,527.09 | 1,963,072.91 | 99.10 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 218,010,600.00 | 216,047,527.09 | 1,963,072.91 | 99.10 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 165,213,600.00 | 165,027,005.35 | 186,594.65 | 99.89 |
| 210101 | Үндсэн цалин | 101,325,200.00 | 101,247,305.35 | 77,894.65 | 99.92 |
| 210102 | Нэмэгдэл | 49,908,000.00 | 49,908,000.00 | 0.00 | 100.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,492,000.00 | 12,391,761.00 | 100,239.00 | 99.20 |
| 210104 | Урамшуулал | 1,488,400.00 | 1,479,939.00 | 8,461.00 | 99.43 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 4,986,600.00 | 3,744,210.44 | 1,242,389.56 | 75.09 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,480,000.00 | 691,449.34 | 788,550.66 | 46.72 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 160,000.00 | 45,589.75 | 114,410.25 | 28.49 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 127,000.00 | 36,471.81 | 90,528.19 | 28.72 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 33,000.00 | 9,117.94 | 23,882.06 | 27.63 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,186,600.00 | 2,961,581.60 | 225,018.40 | 92.94 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 12,787,000.00 | 12,607,083.00 | 179,917.00 | 98.59 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,698,900.00 | 1,603,425.00 | 95,475.00 | 94.38 |
| 210302 | Түлш, халаалт | 10,075,000.00 | 9,990,558.00 | 84,442.00 | 99.16 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,013,100.00 | 1,013,100.00 | 0.00 | 100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 14,972,900.00 | 14,633,588.30 | 339,311.70 | 97.73 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,401,400.00 | 1,401,400.00 | 0.00 | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,475,800.00 | 10,475,800.00 | 0.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,947,600.00 | 1,608,588.30 | 339,011.70 | 82.59 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 626,900.00 | 626,600.00 | 300.00 | 99.95 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 521,200.00 | 521,200.00 | 0.00 | 100.00 |
| 2105 | Нормативт зардал | 12,838,700.00 | 12,838,700.00 | 0.00 | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 11,884,200.00 | 11,884,200.00 | 0.00 | 100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 954,500.00 | 954,500.00 | 0.00 | 100.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 360,100.00 | 360,100.00 | 0.00 | 100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 360,100.00 | 360,100.00 | 0.00 | 100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,303,400.00 | 3,294,400.00 | 9,000.00 | 99.73 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,303,400.00 | 3,294,400.00 | 9,000.00 | 99.73 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,548,300.00 | 3,542,440.00 | 5,860.00 | 99.83 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,633,700.00 | 1,633,700.00 | 0.00 | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 234,500.00 | 234,500.00 | 0.00 | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 331,000.00 | 331,000.00 | 0.00 | 100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 269,700.00 | 269,700.00 | 0.00 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 79,400.00 | 73,540.00 | 5,860.00 | 92.62 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 218,010,600.00 | 216,047,527.09 | 1,963,072.91 | 99.10 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 214,010,600.00 | 210,405,527.09 | 3,605,072.91 | 98.32 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 214,010,600.00 | 210,405,527.09 | 3,605,072.91 | 98.32 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 4,000,000.00 | 5,642,000.00 | -1,642,000.00 | 141.05 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,000,000.00 | 5,642,000.00 | -1,642,000.00 | 141.05 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 23.00 | 21.00 | 2.00 | 91.30 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | 0.00 | 100.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | 0.00 | 100.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 11.00 | 10.00 | 1.00 | 90.91 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10.00 | 9.00 | 1.00 | 90.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 8,319,360.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 6,989,360.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 6,989,360.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,065,860.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,065,860.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 459,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 459,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,464,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,464,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,330,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 1,330,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,330,000.00 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 8,319,360.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 8,319,360.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,224,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,095,360.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасны дагуу эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж, бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант онд аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь "*Байгууллагын ажил үйлчилгээний чанарын түвшнийг дээшлүүлж, цахим шинэчлэлийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, бүх шатны удирдлагын манлайллын дээшлүүлэх, сургалтын чанарыг дээшлүүлж, албан хаагчдын мэдлэг ур чадварыг ахиулах, албаны шуурхай бэлэн байдлыг хангаж, сахилга ёс зүйг төлөвшүүлэх"* гэсэн зорилт тавин ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын харьяа төсвийн байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн хүрээнд явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022.04.29
- "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" ЗГ-ын 2022.05.25-ны 203 дугаар тогтоол
- "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" ЗГ-ын 2022.03.09-ны 107 дугаар тогтоол
- "Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 2022.05.11-ны 192 дугаар тогтоол
- "Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 2022.05.11-ны 194 дүгээр тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд ШШҮХ-ээс шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ШША-ны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн бөгөөд тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 108,832.1 мянган төгрөгөөр буюу 181.5 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* *Мянган төгрөгөөр*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 2,051.7 | 7,126.3 | 5,074.6 |
| Үндсэн хөрөнгө | 57,900.9 | 161,658.4 | 103,757.5 |
| **Нийт хөрөнгө** | **59,952.6** | **168,784.7** | **108,832.1** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 59,952.6 | 168,784.7 | 108,832.1 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **59,952.6** | **168,784.7** | **108,832.1** |

Хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 247.3 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 2,051.7 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 32,093.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 27,019.0 мянган төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 7,126.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 179.2 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 57,900.9 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд ШШҮХ-ээс үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 116,801.9 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,330.0 мянган төгрөг нийт 118,131.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, шилжиж ирсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 684.7 мянган төгрөг тайлант хугацаанд байгуулсан элэгдэл 13,689.7 мянган төгрөг нийт 14,374.4 мянган төгрөгөөр буурч, 161,658.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнг 108,832.1 мянган төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 414,539.2 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 4,000.0 мянган төгрөг нийт зарлагыг 418,539.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 199,162.4 мянган төгрөгийг бууруулан зардлыг 219,376.8 мянган төгрөгөөр хянаж баталжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

2022 оны 12 дугаар сард орсон төсвийн өөрчлөлтөөр 1,366.2 мянган төгрөгөөр бууруулсан байна.Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 214,010.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 4,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 214,010.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 5,642.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 216,474.5 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны цалин, шимтгэлийн зардлаас 1,428.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 179.9 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлуудаас 354.3 мянган төгрөгийг хэмнэж нийт 1,963.1 мянган төгрөг, давсан орлогоос 1,642.0 мянган төгрөг нийт 3,605.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* мянган төгрөгөөр

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 70707-Шүүхийн шинжилгээ | 218,010.6 | 216,047.5 | 1,963.1 | 99.1 |
| 1.1 | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 216,376.9 | 214,413.8 | 1,963.1 | 99.1 |
| 1.2 | 82311-Шүүхийн шинжилгээ тусгай ажил | 1,633.7 | 1,633.7 | 0.00 | 100 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жил нэмэлт санхүүжилтээр Аймгийн ЗДНХ-өөс эзэнгүй цогцос оршуулах болон сургалтын зардалд 5,224.0 мянган төгрөг, өөрийн давсан орлогоос 3,095.3 мянган төгрөг нийт 8,319.4 мянган төгрөгийг хүлээн авч, тээвэр шатахууны зардалд 2,065.9 мянган төгрөг, багаж техник хэрэгсэл худалдан авахад 1,789.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 4,464.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагаа, бүртгэл тайлагналыг сайжруулах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Алтантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар хэрэгжүүлсэн.

Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 12а/06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсөв 219,376.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,193.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,645.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-нд баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага нь төрийн аудитын байгууллага байна гэж заасан. Үүний дагуу “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”-ийг МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар, “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг МУЕА-ын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны А/89 дүгээр тушаалаар баталж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянаж ажилласан болно.

ШША нь тусгай чиг үүргийн байгууллага бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим зүйл заалтад хамаарахгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж, өр төлбөр үүсгэхгүй байх, батлагдсан бүтэц орон тоог баримтлан ажиллах зэргээр зардлыг хэмнэх арга хэмжээг авч ажилласан байна.

ШША нь цалин, шимтгэлийн зардал болон бусад зардлуудаас нийт 1,963.1мянган төгрөг, давсан орлогоос 1,642.0 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгож улсын төсвийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шүүхийн шинжилгээний алба нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 150 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын урьдчилсан болон төлөвлөх шатны ажлыг 2022.11.10-2022.11.12-ны хооронд хийж гүйцэтгэсэн.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 1,258.9 | 1 | 1,258.9 | 100 |
| Албан шаардлага | - | - | - | - | |
| Зөвлөмж | 1 | 0 | 1 | 0 | 100 |
| **Нийт дүн** | **2** | **1,258.9** | **2** | **1,258.9** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цалин хөлс, эм эмнэлгийн хэрэгслийн зардлыг анхааран авч үзнэ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа[1] илрээгүй, харин залруулагдаагүй нийт 865.1 мянган төгрөгийн зөрчил[2] илэрч, 1 албан шаардлага хүргүүллээ.

### 5.1 Албан шаардлага

Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардлаас 410.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 316.5 мянган төгрөгийн барилгын засварын материал худалдан авсан, мөн гэрэл цахилгааны зардлаас 138.6 мянган төгрөгийн интернет, суурин утасны төлбөрийг төлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах",   Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын " Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардал /210501/д тогтоосон норм нормативын дагуу тоо хэмжээг нь тогтоосон эм, урвалж бодис, био бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл ... бүх төрлийн лабораторийн урвалж бодис хамаарна”, "Гэрэл цахилгааны зардалд бүтээгдэхүүн үйлчилгээ нийлүүлэгч байгууллагатай байгуулсан гэрээ болон  цахилгаан эрчим хүч хэмжих тоолуурын заалтын дагуу байгууллагын хэрэгцээнд ашигласан цахилгаан эрчим хүчний төлбөр, өөрийн эх үүсвэрээр цахилгаан эрчим хүчээр хангахад гарсан зардал энд хамаарна " гэснийг зөрчсөн байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*:Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| ШША | 1 | 865.1 | - | - | 1 | 865.1 | - | - | | | | |